



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А1209

Номгон

ГБайгаль орчны тэмдэглэлт өдрүүдээр сургалт,
сурталчилгаа зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 17/59 дүгээр тогтоолоор батлагдсан "Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө"-ний 104 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдээр иргэд, олон нийтэд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, байгаль орчны салбарын хууль тогтоомжийг сурталчлан таниулах, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн боловсрол олгох олон талт сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулсугай.

2.Иргэд, олон нийтэд байгаль орчны хууль тогтоомжийг сурталчлан таниулж, экологийн мэдлэг, хандлага, төлөвшлийг олгох олон талт ажил, арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, төлөвлөгөөний дагуу үр дүнтэй зохион байгуулж, холбогдох тайлан баримтыг Төрийн архивын тасагт шилжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Э.Ганзориг)-т үүрэг болгосугай.

3.Дээрх үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах зардал 5,000,000 (Таван сая) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас зарцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Э.Ганзориг)- зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

624010457